


ЭЦЭГ ЭХ



2010 он 12 сар Анхдугаар

Одоо эхнэр нөхөр биш боловч ‘ЭЦЭГ ЭХ’



Гэр бүл цуцлалт ихэсч буй өнөө үед хүндхэн нөхцөл байдлыг туулан салж буй гэр бүлүүд нь, шинэ амьдралын төлөө зүтгэн ялангуяа насанд хүрээгүй хүүхэдтэй хүмүүстэй бол салсны дараа ч аав ээж гэсэн нэрээ хэвээр нь хадгалж хүүхдээ сайн өсгөж хүмүүжүүлж чадах болуу хэмээн санаа зовдог.



Насанд хүрээгүй хүүхэдтэй гэр бүл нь зөвшилцөлийн гэр гэр бүл цуцлалт, шүүхийн гэр бүл цуцлалтаа үл харгалзан үр хүүхдээ өсгөх талаар хоорондоо сайн зөвлөлдөн шийдэх хэрэгтэй (Иргэний хуулийн 837, 843 бүлэг).

Үр хүүхдээ өсгөх талаар шийдвэрлэхдээ хүүхдийн аз жаргал, хүүхдэд ашигтай талыг харгалзан үзэх ёстой бөгөөд эцэг эхийн тав тух юмуу ашиг сонирхолыг дагаж болохгүй.



Салсан гэр бүлийн хүүхдүүд маш их зовлон хүнд бэрхийг туулж янз бүрийн асуудал үүсгэдэг ба насанд хүрсэн үедээ гэр бүлээсээ салах явдал үүсгэх нь ч бий. Энэ нь “салалт” ын нөлөө биш эцэг эх нь муудалцан, салах явцын таагүй үр дүн юм. Салалтын явцад сэтгэлийн хөдлөлөө барьж, үр хүүхдээ юун түрүүнд бодож хайр халамж анхаарлаа бүрэн хандуулах юм бол хүүхдүүд харин ч илүү гайхалтай сайн өсөж чадна.

Энэхүү ном нь **салж буй эхнэр нөхрийн мэдэх ёстой насанд хүрээгүй хүүхдүүдийн талаарх заавар зөвлөгөө** өгч буй бөгөөд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийлэл зовоох зэрэг эрүүгийн хэрэгтэй холбоотой асуудал гарах тохиолдол болон эмтарианы буруу хэрэглээ, сэтгэцийн өвчин зэрэг онцгой асуудал гарах тохиолдлууд хамааралгүй болно. Мөн энэхүү номонд өгүүлэгдэж буй эцэг эхийн салалтын талаар үр хүүхдүүдийн үзүүлж буй үйл хөдлөлийн онцлог нь тухайн хүүхдийн онцлогоос шалтгаалж үйлдэл нь янз бүрээр илрэх тул асуудалтай үйл хөдлөл мэдэгдвэл даруй мэргэжлийн хүнээс зөвлөгөө авах хэрэгтэй.

ГЭДЭГ НЭРЭЭ САХИЦГААЯ

■ Эцэг эхийн эрх, үүрэг ба асран халамжлагч

Эцэг эхийн аль нь хүүхдийн асран халамжлагчаар тохирох эсэхийг хүүхдийн нийгмийн халамжийг үндэслэн шийдвэрлэсний дараа, онцгой шалтгаан байхгүй бол асран халамжлагчийн талд эцэг эхийн эрх, үүргийг тогтооно. (Асран халамжлагч талд эцэг эхийн эрх, үүрэг байхгүй тохиолдолд хүүхэд ихээхэн хүндрэл бэрхшээл амсах болдог). Бас нэг зүйл нь үр хүүхдээ хувааж авсан тохиолдолд асран халамжлагч тогтоохоос татгалзахыг санал болгодог. Энэ нь үр хүүхдийг дахин шархлуулах болдог.

■ Асран хамгаалах зардал

Үр хүүхдийн амьжиргаа болон өсөлт, боловсролд зайлшгүй асран хамгаалагчийн зардал хэрэгтэй. Хүүхдийн асран хамгаалагчийн эрхийг аваагүй тал нь ямар ч тохиолдолд заавал асран хамгаалагчийн зардалыг өгнө гэж бодон боломжоороо, сэтгэлээсээ төлдөг байх хэрэгтэй.

■ Уулзах эрх

Хүүхдэд аав ээж хоёулаа хэрэгтэй. Хүүхэд эцэг эхийнхээ аль нэгээс тусгаарлагдах тохиолдолд бие махбодь, сэтгэл санаа, хувь хүнийхээ хувьд зөв өсөн торниж чадахгүй. Уулзах эрх нь эцэг эх, үр хүүхдийн хэн хэнд нь хүлээн зөвшөөрөгдсөн эрх юм. Тиймээс асран халамжлагч нь хүүхдийн асран хамгаалагчийн эрхгүй талтай хүүхдээ тайван чөлөөтэй уулзуулах хууль эрх зүйн үүрэгтэй.





Ээ ямар аймаар юм бэ



© Happy Song & Kim

Нялх хүүхдэд эцэг эхийн салалтаас үүдэн гарах үйл хөдлөлийн онцлог
• Айдас зовнил • Өсөлт удаащрах • Эвгүй авир байдал

“Илэрхийлж чадахгүй хэдий ч сэтгэл нь их өвдөнө”

Одоохондоо хүүхэд учраас юу ч мэдэхгүй гэж бодож байна уу? Манай хүүхэд сайхан сэтгэлтэй учраас зүгээр гэж бодож байна уу?

Тийм биш юм.

Хүүхэд жаахан байх тусам харин ч эсрэгээр эргэн тойрны түгшүүр болон зөрчилд эмзэг байдаг. Эцэг эх нь хэрэлдэх юм уу гэнэт хэн нэг нь байхгүй болчихвол хүүхэд маш их айдас, түгшүүрт автдаг. Мөн салалтын стрессээс болоод уур хилэн, уйтгар гуниг дүүрэн аав ээж хүүхдээ асрах үед, хүүхэд асуудалд удаанаар хариу үйлдэл үзүүлэх юм уу өсөлт нь удаашран түүгээр ч зогсохгүй эвгүй зан авир байдал гаргадаг.



Зөвлөгчийн зөвлөгөө

Эцэг эх стресс болон уур хилэн, гунигтай байдлаас болоод хүүхдээ орхигүйн тулд өөрийн сэтгэл зүйн тайван байдлын төлөө бүх хүчээ дайчлан хичээх хэрэгтэй. Аав ээж 2 нь хүүхэдтэйгээ дотно харилцах үнсэх, илэх, тэврэх мөн чин сэтгэлийн ярилцлагаар дамжуулан хүүхдэдээ хангалтай хайр халамж анхаарлыг мэдрүүлээрэй.

Нялх хүүхэд гол асран халамжлагчтай тогтвортой хайрын харилцааг сайн бүрдүүлэх юм бол насанд хүрээд ч гэсэн бусад хүмүүс, нийгэмтэйгээ эв харилцаа тогтоодог. Хүүхэд бага байх тусам эцэг эхийнхээ хэн нэгнээс тусгаарлагдвал өсөлтийн явц, хувь хүн төлөвшилийн зүгээс саатал үүсч болох тул “хүүхдээ том болохоор нь уулзая” гэж болохгүй.



Эмчийн зөвлөгөө

Хүүхдээ асран халамжлагчийн эрхгүй болсон аав(ээж)тэй ч хангалтай, тайван нөхцөл байдалд уулзаж болохоор уулзах эрхийн талаар хэлэлцэн зөвлөлдөөрэй.

Асран халамжлагчийн эрхгүй тал нь заавалчгүй асран халамжлах зардал өгөхөө амлах хэрэгтэй.

Нялх хүүхэд нь хувааж авдаг шиг хэдэн өдөр ээжтэйгээ, хэдэн өдөр аавтайгаа байж болохгүй.

Болж өгвөл гол асран халамжлагчийг тогтон, асран халамжлагчийн эрхгүй болсон тал нь хүүхдийн амар тайван аюулгүй амьдралын явцыг үймүүлэхгүйн тулд тодорхой цагт, үргэлж, богино хугацаатай уулзан хүүхдээ хоолох, хувцаслах, угаах, унтуулах зэрэг зүйлд тусалж болно.



Шүүгчийн шийдвэр



Би яах боллоо?



©happyBong * Ye Rim

Цэцэрлэгийн насны үед эцэг эх салахад хүүхдийн зүгээс гаргах харилу үйлдлийн онцлог

- Гэмших сэтгэл
- Айдас
- Эцэг эхдээ уурлаж буйгаа илэрхийлэх
- Зөрүүдлэх
- Нойргүйдэх, хоолонд дургүй болох
- Эвгүй авир гаргах

“Бүх юм надаас боллоо Би одоо яах болоо?”

Нялх хүүхдүүд нь эцэг эхийнхээ салалтанд маш хүндээр “би буруу юм хийснээс ээж аав минь салж байна” гэсэн гэмших сэтгэл төрдөг. Мөн “аав орхиод явсан юм чинь ээж ч бас намайг хаяж магадгүй” гэсэн айдасг автдаг.

Гэнэт эцэг эхийн аль нэг нь байхгүй болох нь хүүхдэд байгалийн гамшиг тохиолдохтой адил байдаг.

Эцэг эхийн салах шийдвэрийг хүүхдийн төвшинд тохируулан хэлж ярилцаарай.



“Ээж аавынх нь салалт чамаас болоогүй.”

“Ээж аав нь салсан ч хэрэгтэй үе болгонд чинь үргэлж чиний дэргэд байх болно.”

“Чамайг урьдын адил хайрлаж, халамж анхаарал тавих болно.”

Хүүхдийг сайн хүлээн зөвшөөрөх хүртэл нь дахин дахин хэлж өгөөрэй. Мөн хүүхэд мэдэрч буй уур бухимдал ба айдасаа илэрхийлж чадахаар сэтгэл хөдлөлийг нь асуугаарай.

Хүүхэд бага байх тусам асран халамжлагчийн эрхгүй талтай тогтмол, байнга уулзаж болохоор уулзах эрхийг хэлэлцэж зөвлөлдөөрэй.

Асран халамжлагчийн эрхгүй тал нь заавалчгүй асран халамжлах зардал өгөхөө амлах хэрэгтэй.

Эцэг эхийн хооронд эцэг эхийн эрх, үүрэг болон асран халамжлагчийг нь өөрчлөхдөө хүүхдийн нийгмийн халамжийг хамгаас түрүүнд харгалзан үзэжасран халамжлагч эцэг эхтэй нь хэлэлцэж байж шийднэ.



Асран халамжлагчийн эрхгүй тал нь хүүхдийг дагуулж явж хонох маягаар уулзах боломж болон эрхтэй. Гудамж талбай юмуу томоохон дэлгүүр зэрэг газраас илүү гэрээс нь хүүхдээ дагуулж явж, ирэх арга нь илүү тохиромжтой. Энэ үед хүүхэд ая тухтайгаар асран халамжлагчийн эрхгүй талтай уулзаад ирэх боломжийг олгох хэрэгтэй бөгөөд энэ нь хүүхдийг бусдын ая харах болон худал хэлэхгүй болгодог. Мөн удаан хугацаанд уулзаагүй эцэг эх нь хүүхэдтэйгээ ийш тийш явах, том бэлэг өгөхөөс илүү хоолож, усанд оруулж, хувцаслаж, унтуулж асрах нь илүү дээр байдаг.





Аав хэзээ ирэх вэ?



©HappyEong • Y. Kim

Бага насны үед эцэг эх салахад хүүхдийн зүгээс гаргах хариу үйлдлийн онцлог

- Эцэг эх дахин нийлэх эсэх талаарх найдлага
- Сургуулийн амьдралд дасан зохицох хүндрэл бэрхшээл
- Санаа зовнил, хулгай хийх, худал хэлэх, гэрээсээ дайжих, аав ээждээ дургүйцлээ илэрхийлэх

“ЭЭЖЭЭ, ААВ ЭРГЭЖ ИРЭХ БОЛНО ...”

Эцэг эхийнхээ салалтыг ойлгох боловч дахин нийлэх талаар найдан мөрөөддөг. Тиймээс эцэг нх нь эргэн нийлэхэд илүү их гутрал болон уйтгар гунигт автдаг. Сургуулийн амьдрал болон найзуудтайгаа харилцах харилцаандаа асуудал гаргах төдийгүй эцэг эх мөн өөртөө санаа зовон өвдөх ч үе байдаг.



Зөвлөгчийн зөвлөгөө

Эсрэгээр эцэг эхдээ асран хамгаалагч юм уу тайвшруулагчийн байр сууринаас хандах “том хүн” мэт хэрсүү үйлдэл үзүүлэх нь ч байдаг. Салсны дараагаар ч урьдын адил эцэг эх хоёулаа хүүхдээ хайрлаж асрахаа онцлон хэлээрэй.

“Чи хэнтэй амьдармаар байна?” мөн “ээж, аавынхаа салалтын талаар юу гэж бодож байна?” гэх зэрэг асуултаас илүү “Ямар сэтгэгдэл төрж байна” гэж сэтгэгдлийг нь асууж хүүхдийн уур бухимдлаа тайлахад нь сайн тусалж өгөөрэй. Хүүхдийн өмнө асран халамжлагчийн эрхгүй талыг буруутгах болон янз бүрийн болж бүтэхгүй зүйл хэлэх тохиолдолд хүүхэд асран хамгаалж буй хүний талд орон асран халамжлагчийн эрхгүй талыг үзэн ядах болон харилцаагаа таслах гэдэг.

Энэ нь хүүхдэд хувь хүн төлөвшилийн сааталыг авчирдаг.

Асран хамгаалагчийн эрхгүй болсон талд ч гэсэн нааштай сэтгэлээр хандахад нь туслах хэрэгтэй.

Эцэг эхийнхээ дахин нийлэх мөрөөдлийнх талаар ч гэсэн бодит байдалд бүтэхгүй болсныг зөөлнөөр илэн далангүй мэдэгдэх хэрэгтэй. Эцэг эхийнхээ эсрэг хүйсний хүнтэй уулзах харилцааны талаар хүүхдийнхээ сэтгэл санааг харгалзан болгоомжтойгоор мэдэгдэх хэрэгтэй.



Эмчийн зөвлөгөө

Хүүхдийн сургуулийн амьдралд сайтар тусалж чадах асран хамгаалагч болон эцэг эхийн эрх, үүргийг тогтоон, хүүхэд асран хамгаалагчийн эрхгүй болсон талтай ч хангалтай цагийг өнгөрөөхөөр уулзах хуваарийг харилцааг тохилцоорой.



Шүүгчийн шийдвэр

Хүүхдийн төрсөн өдөр, тэмдэглэлт баяр, амралт, дурсамжтай өдрийг тэмдэглэх хуваарь гаргах нь сайн. Хүүхдийн боловсролын зардал цаашид аажмаар өсөх тул заавал асран халамжлах зардлаас гадна боломжийнхоо хэрээр нэмэлт мөнгө өгдөг байх хэрэгтэй.

Би үнэхээр зүгээр
харагдаж байна уу?



©happy Bong + Ye Bin

Өсвөр насны үед эцэг эх салахад хүүхдийн зүгээс гаргах хариу үйлдлийн онцлог

- Дэмий тэнэх
- Сурлагын үзүүлэлт буурах
- Сургуульдаа явах аас татгалзах
- Үйтгэр гунигт автах
- Гэрээсээ дайжих
- Амиа хорлох гэж оролдох

“Би ч бас өөрийнхөө дураар хийх болно!”

Шилжилтийн настай холбоотой гэнэт сэтгэл санааны өөрчлөлт гарах үе бөгөөд эцэг эхийн салалтаас болоод сургуулийн амьдралд асуудал гаргах ба дэмийн тэнэх, гуниглах өвчин тусах, түүгээр ч зогсохгүй амиа хорлохоор оролдох тохиолдол ч байдаг.



Эхийн зөвлөгөө

Хүүхдээсээ шалтгаалаад байхгүй болсон эцэг эхийнхээ аль нэг хоосон орон зайг дүүргэх сэтгэл санааны үүргийг гүйцэтгэх болон үлгэр дуурайлал үзүүлэн хичээл сурлагадаа шамдан гэрийн ажлыг бүгдийг нь хийх зэрэг хэт хэрсүү үйлдэл гаргах нь ч байдаг.

Өсвөр насны үе нь нас биед хүрэхийн өмнөх үе шат юм.

Эцэг эхийнхээ салалтын явцаас ажиглагдах сэтгэл хөдлөл болон зөрчлийг шийдвэрлэх арга нь нас биед хүрсний дараа ч асар их нөлөө үзүүлнэ.

Төлөвшилтэй, аз жаргалтайгаар эсрэг хүйстэнтэйгээ уулзах юмуу, эсвэл салалтын гол суурь болох ч тохиолдол байх ба эцэг эх үр хүүхдүүдийн хоорондын хайр, итгэлцлийн харилцаагаа хадгалахыг хичээх хэрэгтэй.

Салалтын талаар аав ээж хамтдаа хүүхдэдээ ярьж ойлгуулах хэрэгтэй.

Үр хүүхэд салалтыг эсэргүүцэх юм үү дургүйцсэн ч түүний яриаг сайтар сонсон ойлгуулах хэрэгтэй. Салах шийдвэр гаргах гэр бүлийн хуралд үр хүүхдээ оролцуулан өөрийгөө хохирогч гэж ойлгуулахгүй байх нь зөв зүйтэй арга юм.

Гол асран хамгаалагчийн шийдвэрт тулгуурлан хүүхдийн санал хүсэлтийг найрсагаар ойлгон сонголтыг нь дэмжих хэрэгтэй. Намайг сонгоогүй ч гомдож болохгүй. Хүүхэддээхэн нэгнийг нь сонголт хийлгэх нь эцэг эхийн өөртөө итгэх итгэл юм.



Шүүгчийн шийдвэр

Үр хүүхэдтэйгээ хамт амьдрах эсэх нь хамаагүй жирийн үед үр хүүхэдтэйгээ сайтар ярилцаж үзээрэй.

Амралтынх үеэр нь хамтдаа аялалд яваарай. Хүүхэд хайр итгэлцлийг мэдэрвэл, нэгэн өдөр хамт амьдардаггүй ч гэсэн тань дээр ирээдүй болон эсрэг хүйстэний харилцааны талаар зөвлөгөө авахаар ирэх болно.

Асран хамгаалах зардалаа хүүхдээ нас биед хүртэл зайлшгүй хариуцлагатайгаар төлөөрэй.

Сайхан сэтгэлтэй хүүхэд, дуулгавартай хүү хэд, хэрсүү хүүхэд байсан ч эцэг эх нь та юм шүү.

Үр хүүхдэдээ найдах болон үр хүүхдээсээ тайтгарал авах гэж битгий бодоорой.

Үр хүүхдэдээ эцэг эхийн үүрэг хариуцлагыг даалгалгүй та өөрөө “эцэг эх” нь байгаарай.

Тэр хугацаанд таны хүүхэд ‘жинхэнэ хүүхэд шиг таны хүүхэд’ болон эргэн ирэх болно.




Зөвлөгчийн зөвлөгөө

Дасан зохицох чадвар нь дээшилнэ

Салсан гэр бүлийн хүүхэд ч гэсэн эцэг эхийн байнгын хайр халамжийг авч өссөн хүүхдүүд эсрэгээр бусдыг ойлгох уужуу сэтгэлтэй байдаг. Мөн харилцаа тогтоох чадварын хувьд ч нийгэмдээ хурдан дасан зохицож, хөгжиж чаддаг бөгөөд өгөгдсөн нөхцөл байдалд ч гэсэн сайтар дасан зохицож буй дүр төрх ажиглагддаг. Үүнийг нэг үгээр хэлэх юм бол хүүхдийн 'дасан зохицох хүч чадвар' өндөрсөж байна гэж үздэг.

Хүүхэдтэйгээ илүү их ярилцан,
тусалж,
хайрлаарай!





ХҮҮХДИЙНХЭЭ ТӨЛӨӨ ҮҮНИЙГ ЗААВАЛ!

Хүүхдийн аав (ээжтэй) бүү хэрэлдэн муудаарай.

Хань чинь хэдий буруу зүйл хийсэн ч гэсэн тэр асуудал нь эхнэр нөхрийн л асуудал болохоос биш, хүүхдийн хувьд эрхэм чухал зүйл эцэг эх юм.

‘Эцэг эхийн хэрүүлээс’ үүдсэн уур хилэн, айдас, гомдол нь хүүхдийн насан туршийн амьдралд муу нөлөө үзүүлж болзошгүй.

‘Эв найрамдалтай’ салаарай. Хань чинь салсны хойно ч гэсэн энхрий хүүхдийг чинь өсгөх харилцан түнш чинь шүү.

Эцэг эх хамтдаа үр хүүхдэдээ бодит байдал болон салалтын талаар мэдэгдээрэй.

Эцэг эхийн салалт үр хүүхдэд гэнэтийн цочрол болохгүй байх талаас нь үр хүүхдэдээ сайтар тайлбарлаж өгөөрэй.

‘Чиний буруу ерөөсөө байхгүйгэдгийг ойлгуулан, үр хүүхдийнхээ сэтгэл санааны байдлыг асуун сэтгэлээ нээн гаргахад нь туслах хэрэгтэй. Салалтын дараах төлөвлөгөө нь мэдээж ямар ч асуулт байсан чин сэтгэлээсээ дахин дахин давтан хариулж өгөх хэрэгтэй.

“Хайртай” гэж байнга хэлээрэй.

“Аав ээжийн чинь салалт чамаас болоогүй.”

“Аав ээж чинь салсан ч хэрэгтэй үед чинь үргэлж чиний хажууд байх болно.”

“Чамайг үргэлж хайрлан туслах болно.” гэж байнга хэлж өгөөрэй.

Хамтдаа амьдарч чадахгүй ч үргэлж уулзан байнга ярилцдаг байх хэрэгтэй.

Эхнэр нөхрийн салалт нь үр хүүхдээс нь ч гэсэн салгах үр дагавар авчирч хэрхэвч болохгүй.

Хүүхдэд эцэг эх хоёулаа хэрэгтэй.

Ялангуяа хүүхэд жаахан байх тусам эцэг эхийнхээ хэн нэгнээс тусгаарлагдах нь хувь хүний төлөвшилд саатал авчирч болзошгүйг сайтар анхаараарай.

Хүүхэд жаахан байх тусам үргэлж мөн тогтмол хоорондоо уулзан ярилцдаг байх хэрэгтэй.

Асран хамгаалагч нь үр хүүхдээ асран хамгаалагчийн эрхгүй болсон талтай нь тайван уулзуулахад туслах хэрэгтэй.

Хэрэлддэг аав ээжийн дунд ирэн очин уулзах нь эсрэгээр хүүхдэд сэтгэл санааны асуудалыг үүсгэж болзошгүй юм. Эцэг эх нь хоорондоо эвтэй найрамдалтай гэж мэдэрч байж чөлөөтэй амар тайван ирж очин хүүхэд шиг хүүхэд болж өсөх болно. Хүүхэд ая тухюмуу, худал ярихаас болгоомжлох хэрэгтэй.

“Миний хүүхэд зүгээр” гэсэн бодлоо орхиорой.

Зөвхөн гадагшаа илэрхийлэхгүй байгаа хэрэг юм. Салалт нь эцэг эхээс илүү үр хүүхдэд илүү хүндээр тусдаг.

Хэрсүү үлгэр жишээ өсч хүмүүжиж байгаа мэт харагдавч хүүхэд хожим өөрийн гэрлэлтийн тал дээр алдаж болох юм. Хүүхдийн зүрх сэтгэл болон үйл хөдлөлийг сайтар ажиглан анхаараарай.

Хүүхэдтэйгээ илүү их ярилцан тусалж хайрлаарай.

‘Хүүхдийнхээ төлөө сайтар анхааралтай бөглөөрэй’



Дараах тест нь салахаар завдаж буй эцэг эхчүүдийн заавал сахин биелүүлэх зүйл юм.

Та хэдийн хийгээд эхэлсэн зүйлүүдээ шалгаарай. Энэ нь хүүхдийн дасан зохицлын төлөө таны хэр их тусламж үзүүлж байгааг харуулж өгөх болно. Хийж өгөхийг хүсч буй зүйлүүдээ тусдаа бөглөөрэй.

- Өөрийн хүүхдүүдэдээ “салалт нь та нарын буруугаас биш” гэж тодорхой хэлж өгнө.
- Хүүхдүүдийнхээ өмнө эсрэг талынхаа талаар таагүй байдлаар мөн уурлан ярихгүй.
- Хэрвээ би өөдрөгөөр ярьж чадахгүй бол ярихаа бүрмөсөн зогсооно.
- Хүүхдүүдийн өмнө эсрэг талтайгаа муудалцахгүй байхыг хичээнэ.

- Хүүхэд нэг бүртэй цагийг өнгөрүүлэхийн тулд онцгой хичээнэ.
- Хүүхдүүдэдээ аав(ээж)даа сайн байсан ч зүгээр гэж хэлж өгнө.
- Хэдийгээр хүүхэд ба эсрэг талын хооронд дуурайсан зүйл байх, би тэрэнд нь дургүй хэдий ч, хүүхэд болон урьдын нөхөр(урьдын эхнэр)тэйгөө харьцуулахгүй.

- Хүүхдүүдийн үзүүлж буй таагүй байдал, айдас, зөрчлийн талаар эсрэг талын буруу гэж ойлгуулах буюу буруутгахгүй.
- Хүүхдүүд эцэг эхийнхээ салалтын талаар ичгүүр гутамшгийг мэдрэхгүй байхаар тусална.
- Хүүхдүүдийн хичээл сурлаганд анхаарал тавина.

- Хүүхдүүдийн амьдралд нэг дор гэнэтийн том өөрчлөлт гаргахгүйгээр зохицуулна.
- Гэрийн ажлаа сайн хариуцаж ээж(аав)ийн хоосон орон зайг мэдрэхгүй байхаар болгоно.
- Хүүхдүүдээс шууд хэнтэй амьдармаар байгааг нь, хэнд хайртайг нь асуухгүй.
- Хүүхдүүд өдөр тутмын үйл ажиллагаагаа хичээнгүй үр дүнтэй хийхэд нь тусална.

- Бололцооньхоо хэрээр өөрийн сэтгэл хөдлөлөө зохицуулж, хүүхдүүд өөрийн байгаа байдлаараа биш том хүн шиг үүрэг хүлээх гэж хичээдэггүй байх талаас нь зохицуулна.
- Хүүхдийг том хүн болох өөрийн түвшинд тааруулах гэхгүй.
- Салалтаас болоод би ялагдагч болсон хэрэгбиш гэдгийг ойлгож байгаа.

“За, одоо хүүхдээ өсгөх асран халамжлах төлөвлөгөөгөө гаргаж үзье.!”

1 Эцэг эхийн эрх, үүрэг болон асран халамжлагч

↳ Ээж болон аавын хэн нь голчлон хүүхдийг өсгөх нь дээр вэ?

- Эцэг эхийн ашиг сонирхол, ая тухаас илүүтэйгээр хүүхдийн аз жаргал ба тав тухтай амьдралыг эхлээд бодож үзээрэй.
- Эцэг эхийн аль тал асран халамжлах орчин нь тогтвортой, ая тухтай байр байдалтай байгааг харгалзан үзэх хэрэгтэй.
- Харилцан зөвшилцсөн салалт болох тусам “хамтран асран халамжлах” ч бололцоотой.

2 Харилцан уулзах

↳ Хамт амьдардаггүй эцэг эхтэйгээ хэзээ, хаана, яаж уулзах нь дээр вэ?

- Байнгын ая тухтай уулзаж болох цаг, газар, арга зэргийн тухай бодож үзээрэй.
- Төрсөн өдөр, тэмдэглэлт баяр, сургуулийн амралт, амралт зэргээ яаж өнгөрөөх нь аятай болохыг тодорхой төлөвлөж үзээрэй.
- Хүүхдийн өссөн торниж буй үе шат зэргийн онцлогийг сайтар бодолцож, амласан зүйлээ заавал биелүүлээрэй.
- Уулзах үед хэрэгтэй мэдээлэл дамжуулах болон нөхцөл байдлыг ойлгоход туслах асран халамжлах дэвтрийг ашиглаарай.

3 Асран халамжлах зардал

↳ Хамт амьдардаггүй эцэг эх асран хамгаалах зардлын хичнээнийг яаж төлөх нь дээр вэ?

- Асран хамгаалах зардал нь ханийнхаа төлөө биш тэр чигээрээ хүүхдэд зориулсан гэдгийг санаж явах хэрэгтэй.
- Асран хамгаалах зардлын хэмжээ болон төлөх аргыг нарийн хэлэлцэж тохиролцон, хоорондоо тохиролцсон асран хамгаалах зардлаа аль болох тогтмоларгаар төлөхийг хичээгээрэй.
- Асран хамгаалах зардлыг төлөөгүй гээд хүүхдэдтэйгээ уулзах уулзалтыг нь хорихгүй байх хэрэгтэй.

→ Хүүхдийн аз жаргал, эрх ашгийг юун түрүүнд бодолцсон төлөвлөгөө гаргасан уу?

→ Ханьтайгаа зөвлөлдөж гаргасан уу?



“Эцэг эх” гэсэн нэрээ сахин хамгаалах гэж буй хүмүүст урам дэм өгөхийн ялдамдхэцүү бэрхшээлтэй тулгарах үед мэргэжлийн хүнээс тусламж авах нь зүйтэй юм.





Энэхүү ном нь бүх улсын шүүхийн албан хаагч, гэр бүл судлаач болон бусад мэргэжилтнүүдийн хийсэн “Эцэг эхийн боловсрол олон нийтийн судалгааны нийгэмлэг” ээс хийсэн судалгаагаар хийгдсэн болно. “Эцэг эхийн боловсрол олон нийтийн судалгааны нийгэмлэг” ийн зөвшөөрөлгүйгээр олшруулж, тараахыг хориглоно.